

МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 26/1

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ)-ны 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн ээлжит бус хуралдаанаар Монголбанкнаас МБХ-ны гишүүдэд банк, санхүүгийн салбарын өнөөгийн байдал, хэрэглээний зээлийн арга хэмжээний талаар танилцуулж МБХ-ноос холбогдох бодлогын шийдвэрүүдийг гаргав.

Хуралдааны эхэнд Монголбанкнаас 2025 оны 11 дүгээр сарын байдлаар банкны системийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 21.0 хувьд хүрч зээл, ДНБ-ий харьцаа урт хугацааны трендээсээ давсан хэвээр байгааг танилцууллаа.

Монголбанкнаас банкны эх үүсвэрийг бизнесийн зээлд чиглүүлэх, иргэд болон өрхүүд хэрэглээгээ цалин, орлого, хуримтлалаасаа зарцуулах тогтолцоо руу шилжих бодлогыг хэрэгжүүлж байгаагийн нөлөөгөөр хэрэглээний зээлийн банкны нийт зээлийн багцад эзлэх хувь 36.2 хувиас 30.1 хувьд хүрч буурлаа. Түүнчлэн 2025 оны 11 дүгээр сарын байдлаар хэрэглээний зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 13.5 хувьд хүрч буурав. Хэрэглээний зээлийн өсөлт нь ӨОХ-ны хязгаарлалтгүй тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлтөөс голлон хамаарч, тэтгэврийн зээл жилийн 46.4 хувиар өссөн байна.

Банкны салбарын хэрэглээний зээлийн үлдэгдлийн 27.8 хувь нь ӨОХ нь 50-иас дээш хувьтай зээлдэгчдэд хамаарч байгаа бөгөөд үүнд банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагаас авсан давхар зээл нөлөөлж, эдгээр зээлдэгчдийн өрийн дарамт өндөр байгаа, түүнчлэн, чанаргүй зээлийн өсөлт өндөр байгааг хэлэлцэв.

Монголбанкнаас цаашлаад Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсөвт боловсрол болон эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалинг нэмэгдүүлэхэд 900 орчим тэрбум төгрөг нэмж зарцуулагдахаар байгаа нь тодорхой сувгуудаар дамжиж хэрэглээний импортыг нэмэгдүүлэх; ханш, төлбөрийн тэнцлийн дарамтыг өсгөх; эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлэн зээлийн халалттай байгаа энэ үед банкны салбарт эрсдэл хуримтлуулж болзошгүй юм. Улсын секторын цалингийн энэхүү өсөлтийг хувийн сектор дагах тохиолдолд хэрэглээний зээлийн эрэлт улам эрчимжиж инфляцын дарамтыг нэмэгдүүлнэ.


Ингээд Монголбанкнаас макро, санхүүгийн орчны төлөв байдлыг харгалзан i) шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 45 хувиар шинэчлэн тогтоох, ii) төгрөгийн болон гадаад валютын заавал байлгах нөөц (ЗБН)-ийн хэмжээг тус бүр 1 нэгж хувиар нэмэгдүүлж харгалзан 14 хувь, 19 хувьд хүргэх саналуудыг МБХ-ны гишүүдээр хэлэлцүүлэв.

МБХ-ны гишүүдийн зүгээс хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг чангаруулах нь хэрэглээний зээлийн эрэлтийг илүү өндөр хүүтэй, зохицуулалт султай бусад салбар луу


шилжих эрсдлээс сэргийлэх шаардлагатай талаар саналаа илэрхийлэв. Энэхүү асуудлыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулж, Санхүүгийн зохицуулах хороотой бодлогын уялдаатай ажиллаж байгаа талаар мэдээлэл танилцуулав. МБХ-ны гишүүд Санхүүгийн зохицуулах хороотой харилцан уялдаатай ажиллаж буй явдал нь чухал ач холбогдолтой бөгөөд цаашид уялдааг гүнзгийрүүлэх нь зүйтэй талаар байр сууриа илэрхийлсэн болно.

Ийнхүү МБХ-ны гишүүд банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 45 хувиар шинэчлэн тогтоох, төгрөгийн болон гадаад валютын ЗБН-ийн хувь хэмжээг тус бүр 1 нэгж хувиар нэмэгдүүлж, харгалзан 14 хувь, 19 хувьд хүргэх Монголбанкны саналыг хэлэлцсэний эцэст илээр санал хурааж, гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэнээр МБХ-ны ээлжит бус хуралдаан өндөрлөв.

Бодлогын саналын шийдвэр



Банкнаас шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлийн ӨОХ-ны дээд хязгаарыг 45 хувиар шинэчлэн тогтоох



Төгрөгийн болон гадаад валютын ЗБН-ийн хэмжээг тус бүр 1 нэгж хувиар нэмэгдүүлж 14 хувь болон 19 хувиар тогтоох